



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 01

Мандалговь

**“Дундговь-Ус” ОНӨҮГазрын удирдах
зөвлөлийн дарга томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3 а, ж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн 21.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг: “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Удирдах зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч
- Гишүүдэд: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн
- Хот тохижуулах газрын дарга
- Аймгийн ИТХ-ын төлөөлөл
- Иргэний төлөөлөл
- Нарийн бичиг: Аймгийн ОНӨГ-ын дарга

Хоёр: Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан дүрмийг мөрдөж ажиллахыг Удирдах зөвлөлд даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

Дөрөв: Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 21, 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

